1925

**УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2025.12.04 № 1/1853

танай 2025.11.24-ны № 4/5575 -т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 4/5575 тоот албан бичгийн дагуу Эрүүл мэндийн яамны дэргэдэх жендэрийн салбар зөвлөлийн баталсан "Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 2025 оны хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 8 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.БЯМБАСҮРЭН

АТА9996 90771
9023050128

142252974

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

**/УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ/**

| | Бодлогын зорилт, зорилго | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Биелэлт, үр дүн | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.1 Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгана.** | | | | | |
| 1 | ЖЭТБХСДС 1.1.1 ЖҮХЖҮАТ 2.1.25 Эрүүл мэндийн салбарын жендэрийг бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрүүл идэвхтэй амьдралын мэдлэг, хандлага, дадлыг жендэрийн мэдрэмжтэй хэвшүүлэх чадавх бүрдүүлнэ. | Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг танилцуулах сургалт зохион байгуулах | Сургалт зохион байгуулсан ЭМБ-ын сургалтад хамрагдсан ажилтан хүйсээр | Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг 2025 оны Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтад хавар, намрын элсэгчдэд зориулсан уламжлалт чиглүүлэх сургалтыг энэ оны 04 дүгээр сарын 04 болон 10 дугаар сарын 10-ны өдөр амжилттай зохион байгуулсан. УНТЭ-ийн 100 жилийн түүхэн ой, мөн Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт албан ёсоор эхэлсний 25 жилийн ой тохиож буйгаараа онцлог бөгөөд тус эмнэлгийг сонгон суралцахаар ирсэн нийт 350 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд чиглүүлэх сургалтад хамрагдсан. Сургалтын хүрээнд УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн албаны дарга “Жендэрийн ойлголт ба жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” сэдвээр хоёр удаагийн сургалтыг явуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, мэдлэг, хандлагыг сайжруулахад чиглэсэн чухал мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан. | 90% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |   *Зураг 1. Сургалтын явцаас* | |
| 2 | | ЭМБ-дад Жендэрийн аян зохион байгуулах | | Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” уриан дор Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг тэмдэглэн, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан ажиллаж эхэллээ. Аяны хүрээнд боловсруулсан төлөвлөгөө нь 2 зорилт, 3 арга хэмжээ-тэй бөгөөд одоогоор хэрэгжилт 95 хувьтай байна. Аяны үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдал, цахим болон технологийн орчинд үүсэж буй хүчирхийлэлтэй тэмцэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх ажлууд түлхүү багтсан юм. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Эмнэлгийн зүгээс 2025 оны 12 дугаар сарын 15- | 90% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ны өдөр Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна.<br><br>*Зураг 2. Аяны төлөвлөгөө*<br>Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд Жендэрийн үндэсний хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл хамтран төрийн байгууллагууд дахь жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэй удирдлагуудын манлайлал, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Авлигын эсрэг эмэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” сэдэвт уулзалтыг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтад төрийн албаны шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэй удирдлагууд оролцож, байгууллага, салбар салбартаа хэрэгжүүлж буй сайн туршлага, үр дүнтэй арга зам, авлигын эсрэг оролцоог нэмэгдүүлэх боломжуудын талаар санал солилцсон. Уулзалтад Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Захиргаа, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хүний нөөцийн албаны дарга оролцож, байгууллагынхаа жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, туршлага, тулгамдсан асуудлын талаар хуваалцсан<br><br>*Зураг 3. Уулзалтын явцаас*<br><br>Эрүүл мэндийн яам, НЭМҮТ, ДЭМБ, Жендэрийн үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний комисс болон холбогдох мэргэжлийн байгууллагуудаас боловсруулсан мэдээлэл түгээх контентуудыг ашиглан Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг жендэрийн тэгш байдал, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээ мэдээлэл, зөвлөмжүүдийг тогтмол олон нийтэд хүргэн ажиллаж байна. УНТЭ-ийн албан ёсны мэдээллийн сувгууд болох цахим фэйсбүүк хуудас, хамт олны групп, мөн гадаад, дотоод вэбсайт-д холбогдох контентуудыг байршуулах замаар ажилтнууд болон олон нийтэд үнэн бодит, хүртээмжтэй мэдээллийг тасралтгүй түгээж, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж байна. https://www.unte.moh.gov.mn/a/909 https://www.facebook.com/firsthospitalofmongolia/ тус холбоосоор орж танилцана уу. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | <br>*Зураг 4. Мэдээлэл байршуулсан явцаас* | |
| 15 | ЖЭТБХСДС 1.1.7 ЖҮХЖҮАТ 2.1.31 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетийг стандартын дагуу аймаг, дүүрэг бүрд байгуулж, хүний нөөцийг бэлтгэх, тоног төхөөрөмжөөр хангах. | Эрэгтэйчүүдийн кабинетийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах | Стандартын дагуу тохижуулсан кабинет | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13-р зүйлийн 13.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020 оны 07 сарын 01-ний өдрийн дугаар 99-р захирамжаар батлагдсан “Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3 дахь заалтын хүрээнд төрөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээ бий болгох зорилгын дор УНТЭ-ийн Урологи Андрологийн төв нь ‘Эрэгтэйчүүдийн кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам батлах тухай тушаалыг боловсруулсан бөгөөд уг журмыг ЭМС-ын 2022 оны 09 сарын 05 өдрийн А/449 тоот тушаалаар батлуулсан бөгөөд уг журмын дагуу эрэгтэйчүүдэд андрологийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>УНТЭ-ийн Урологи-Андрологийн төв нь 2025 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар эмч-10, сувилагч-10, туслах сувилагч-2, үйлчлэгч-2 нийт 26 ажилтантайгаар эмчилгээ үйлчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд УАТ нь 18227 үйлчлүүлэгч нарт үзлэг оношилгоо шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажилласан. | 100% |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><th>№</th><th>Үзүүлэлт</th><th>2025 оны 11 сарын байдлаар</th></tr>
<tr><td>1</td><td>Эрэгтэйчүүдийн үзлэг</td><td>13807</td></tr>
<tr><td>2</td><td>Эрэгтэйчүүдийн дуран оношилгоо</td><td>1020</td></tr>
<tr><td>3</td><td>Үрийн шингэний шинжилгээ</td><td>20</td></tr>
<tr><td>4</td><td>Хийгдсэн мэс засал (кабинетаар)</td><td>3380</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td>18227</td></tr>
</table>
</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>16</td>
<td></td>
<td>Андрологи, урологийн чиглэлээр хүний нөөцийг тасралтгүй сургаж бэлтгэх</td>
<td>Сургагдсан хүний нөөц</td>
<td>УНТЭ нь Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал /Андрологи/ төрөлжсөн мэргэжлийн сургалтыг зохион байгуулах эрхтэй байгууллага бөгөөд 2025 онд нийт 1 эмч суралцаж төгссөн. Одоогоор Андрологийн чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн сургалтад 2 эмч суралцаж байна.<br><br>АЗДТГ-ын дэмжлэгтэйгээр “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн нээлтийн үйл ажиллагаа, эрэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг болон сургалтуудыг Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Сайншанд сумын ӨЭМТ-үүдтэй хамтран 2025 оны 03 дугаар сарын 18–23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Урологи-Андрологийн төвийн эмч нар болон “Гурван гал” эмнэлгийн урологийн нарийн мэргэжлийн эмч нарын баг 13 сум, 11 байгууллагын нийт 207 эрэгтэйд үзлэг, эхо шинжилгээ хийж, 80 гаруй өвчлөл илрүүлэн шаардлагатай эмийн эмчилгээ, зөвлөгөөг өгсөн. Орон нутагт хийх боломжгүй дурангийн мэс заслыг 3 иргэнд амжилттай хийсэн. Үйл ажиллагааны хүрээнд “Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хөвгүүдийн эрүүл мэнд” сэдэвт сургалтуудыг 13 сумын 631 эрэгтэй, ерөнхий боловсролын сургуулийн 10–12-р ангийн хөвгүүдэд зохион байгуулж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, өөртөө анхаарах дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээллийг</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | өгч, 200 ширхэг эрүүл мэндийн зөвлөмж тараасан. Иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Дорноговь аймгийн DTV телевизтэй хамтран “Охид, хөвгүүдийн цаг”, “Эмчийн зөвлөгөө” зэрэг нэвтрүүлгүүдийг бэлтгэн үзэгчдэд хүргэж, олон нийтийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан.<br><br>*Зураг 5. Үзлэг, сургалтын явцаас*<br><br>УНТЭ-ийн УАТ-ийн их эмч П.Мягмарсүрэн 2025 оны 05 сард Тайван улсын Цэргийн эмнэлэгт Андрологийн чиглэлээр суралцсан. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | <br><br>*Зураг 6. Сургалтын явцаас*<br><br>УНТЭ-ийн УАТ-ийн их эмч М.Эрдэнэсайхан 2025 оны 01 сард Шанхай хотод “Аарцаг чөлөөлөх мэс заслын олон улсын сургалтад” хамрагдсан.<br><br>*Зураг 7. Сургалтын явцаас* | |
| | | | | | Гүйцэтгэлийн хувь | 95% |

Хянасан: Г.Алтанцоо, Нийгмийн эрүүл мэндийн албаны дарга

Боловсруулсан: Д.Гандулам, Нийгмийн эрүүл мэндийн албаны мэргэжилтэн